МЭДЭЭ · 2021 оны 6-р сарын 15

ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЛИЙГ БУУРУУЛАХАД АНХААРЧ АЖИЛЛАХ ШААРДЛАГАТАЙ ГЭЖ ДҮГНЭЖЭЭ



Өмнөговь аймгийн прокурорын газраас аймгийн хэмжээнд үйлдэгдсэн гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой гэмт хэргүүдийн шалтгаан нөхцөлийг судалж, холбогдох арга хэмжээг авч ажиллаж байна.

Тус аймагт энэ оны эхний 5 сарын байдлаар хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулсан нийт хэргийн 5.1 хувь нь гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг эзэлж байгаа бөгөөд өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 77.7 хувиар өссөн байна. Тодруулбал, энэ төрлийн хэрэг нийт 22 бүртгэгдсэн ба 18 хэрэгт нь прокурорын яллах дүгнэлт үйлдэн шүүхэд шилжүүлж шийдвэрлүүлжээ. Түүнчлэн дээрх хугацаанд бага насны хүүхдийг хүчирхийлсэн 9 гэмт хэрэг үйлдэгдсэнээс жирэмсэн болгосон, үр хөндүүлсэн 5 тохиолдол гарсан байна.

Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг өссөн шалтгаан нөхцөл нь архидалт, ажилгүйдэлтэй холбоотой байгаагаас гадна Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай

хуулийг сурталчлах, иргэдэд таниулах ажил хангалтгүй байгаатай холбоотой байна гэж үзжээ.

Иймд тус прокурорын газраас бага насны хүүхдийг бэлгийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэргийг бууруулахад аймгийн хууль хяналтын байгууллага, Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар болон салбар дундын байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах шаардлагатай талаар холбогдох байгууллагуудад мэдээлэл хүргүүлсэн байна.

Мөн аймгийн прокурорын газрын ерөнхий прокурорын орлогч Т.Нансалмаа тус аймагт зохион байгуулагдаж байгаа “Хүчирхийлэлгүй нийгмийг бүтээхэд иргэн бүрийн оролцоо” аяны хүрээнд хийсэн “Гэр бүлийн хүчирхийллийг бууруулах” Фокус бүлгийн ярилцлагад оролцжээ.

Эх сурвалж: https://prosecutor.mn/post/2554